



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2024.04.19 № 456  
танай \_\_\_\_\_ -ы № \_\_\_\_\_ -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ГАЗАРТ**

Аймгийн Засаг даргын 2023 оны нэгдсэн  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг  
хүргүүлж байна.

Хавсралт <sup>34</sup> хуудас

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Ж.ГАНБААТАР



232430768



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ**

2024 оны 09 дугаар сарын 18

Дугаар A/11

Чингис хот

**Аудитын тайлан  
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, МУЕА-ын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хэнтий аймгийн Засаг даргын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг аудитор (Ц.Хатанболд)-д даалгасугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Ц.Чогсомжав)-т зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор (Ц.Хатанболд)-д даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

232410022



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны үйл ажиллагааны  
төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

## ХЭНТИЙ АЙМГИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аймгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 86.7 хувь байна.

**АУДИТЫН КОД: ХЭА-2024/01/НА-СТА-ТЕЗ**

Чингис хот 2024 он  
Цахим хуудас: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Дарга, тэргүүлэх аудитор:	Ж.Ганбаатар
Утас:	70562112
Аудитын менежер:	Д.Оюунтуяа
Утас:	99775390
Аудитор:	Ц.Хатанболд
Утас:	91925552
Аудитор:	Х.Еркегүл
Аудитор:	Б.Хуланхатан

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг

[khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу.

Тайланг бэлтгэсэн:  
Хэнтий аймаг дахь  
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх  
аудитор Ж.Ганбаатар

Аудитын менежер  
Д.Оюунтуяа

Аудитор:  
Ц.Хатанболд  
Х.Еркегүл  
Б.Хуланхатан

2024 оны 04 сар

Аудитын тайлан,  
дүгнэлттэй холбоотой  
асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах  
зүйл байвал 70562147,  
70562112 дугаарын утас,  
[khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)  
хаягаар харилцана уу.

ХАЯГ:Хэнтий аймгийн  
Хэрлэн сум, аймгийн  
ЗДТГ-ын байр, 318 тоот

## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Үндсэн мэдээлэл	5
<b>БҮЛЭГ 1. Хуульд заасан үндэслэл бүрдээгүй байхад төсөвт тодотгол хийсэн байна.</b>	
1.1 Төсвийн төсөл боловсруулах удирдамж, чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байна	7
1.2 Төсвийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн байна	7
1.3 Төсөвт тодотгол хийх үндэслэл бүрдээгүй байхад 3,052.1 сая төгрөгийн төсвийн тодотгол хийсэн байна	8
<b>БҮЛЭГ 2. Төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.</b>	
2.1 ААНОАТ-ыг үндэслэлгүй 4,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталснаас аймгийн төсвийн орлого тасарсан байна.	10
2.2 Сангуудын орлого 762.8 сая төгрөгөөр тасарсан байна.	13
2.3 Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт 103.1 хувь байна	15
<b>БҮЛЭГ 3. Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 86.7 хувь байна.</b>	
3.1 Хувийн хэвшлийн байгууллагад 324.4 сая төгрөгийн татаас олгосон нь хууль тогтоомжид нийцэхгүй байна.	15
3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн 899.4 сая төгрөгийн 37 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.	19
3.3 Нэмэлт санхүүжилтийн дансны эцсийн үлдэгдэл 211.4 сая төгрөг нь аймгийн захиалагчийн хяналт дансны үлдэгдэл байна	21
3.4 Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан хуульд заагдсан бүрэлдэхүүн хэсгийг бүрэн хангасан байна	21
<b>БҮЛЭГ 4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b>	22
<b>БҮЛЭГ 5. Орон нутгийн хөрөнгө оруулалт</b>	23
<b>БҮЛЭГ 6. Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт</b>	26
<b>Аудитын дүгнэлт</b>	28
<b>Зөвлөмж</b>	29
<b>Хавсралтууд</b>	30

**Хавсралтын товъёг**

<i>Хавсралт №1</i>	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
<i>Хавсралт №2</i>	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан
<i>Хавсралт №3</i>	Аймгийн төсвийн орлогын биелэлт
<i>Хавсралт №4</i>	Сумдын төсвийн орлогын биелэлт
<i>Хавсралт №5</i>	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл
<i>Хавсралт №6</i>	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын биелэлт
<i>Хавсралт №7</i>	Хөрөнгийн зардлын гүйцэтгэл
<i>Хавсралт №8</i>	Хоршоо хөгжүүлэх сангийн гүйцэтгэл
<i>Хавсралт №9</i>	МУ-ын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилт
<i>Хавсралт №10</i>	Албан шаардлагууд
<i>Хавсралт №11</i>	Судалгаа

**Хүснэгтийн товъёг**

<i>Хүснэгт №1</i>	Орлогын төлөвлөлт
<i>Хүснэгт №2</i>	Төсвийн зарлагын төлөвлөлт
<i>Хүснэгт №3</i>	Төсвийн тодотгол /Орлого/
<i>Хүснэгт №4</i>	Орон нутгийн зарлагын төлөвлөгөөний харьцуулалт
<i>Хүснэгт №5</i>	Төсвийн санхүүжилтийн эх үүсвэр
<i>Хүснэгт №6</i>	Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
<i>Хүснэгт №7</i>	Орлогын төлөвлөгөө их хэмжээгээр тасарсан сумдын татварын орлогын
<i>Хүснэгт №8</i>	Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого
<i>Хүснэгт №9</i>	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого
<i>Хүснэгт №10</i>	Сангуудын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
<i>Хүснэгт №11</i>	Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
<i>Хүснэгт №12</i>	Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт
<i>Хүснэгт №13</i>	Төсвийн гүйцэтгэл, хөтөлбөр арга хэмжээний ангиллаар
<i>Хүснэгт №14</i>	Төсвийн гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар
<i>Хүснэгт №15</i>	Хөрөнгийн зардлын гүйцэтгэл төрлөөр
<i>Хүснэгт №16</i>	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасны төлөвлөгөө, гүйцэтгэл
<i>Хүснэгт №17</i>	ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны нэгтгэл
<i>Хүснэгт №18</i>	Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал
<i>Хүснэгт №19</i>	Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөв
<i>Хүснэгт №20</i>	Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
<i>Хүснэгт №21</i>	Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
<i>Хүснэгт №22</i>	Зөвлөмжийн хэрэгжилт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДҮАХ	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
АТӨЯХ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгсэл
БОНАТ	Борлуулалтын орлогод ногдох албан татвар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАХ	Төсөл арга хэмжээ
МУ	Монгол улс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮҮЗАУс	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус
ҮХХБО	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## Аудитын тайлан

### Ерөнхий зүйл

**Аудитын нэр:** “Хэнтий аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”

**Аудитын код:** ХЭА-2024/01/НА-СТА-ТЕЗ

### Аудитын хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт:

Хэнтий аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, аймгийн ИТХ болон Засаг даргад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх
2. Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
3. Орон нутгийн төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан эсэх
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх
5. Орон нутгийн хөрөнгө оруулалтын 2023 оны хэрэгжилт үр дүнтэй байсан эсэх
6. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажилласан эсэх

### Хамарсан хүрээ:

Аудитад аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэнцэл, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, Татварын орлогын гүйцэтгэлийн мэдээ болон бусад холбогдох баримт материалыг хамруулав.

### Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, судалгаа тодруулга авах, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аргыг ашиглахаас гадна аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- ✓ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- ✓ Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- ✓ Хэнтий аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө
- ✓ Хэнтий аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
- ✓ Аймаг болон сумдын төсвийг баталсан ИТХ-ын тогтоолууд
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд
- ✓ Бусад дүрэм журам, тушаал, шийдвэр

### **Үндсэн мэдээлэл**

Монгол Улсын Их хурлаас 2022 онд “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг шинэчлэн баталж, дагаж мөрдсөн ба түүнтэй холбоотой журам зааврыг Засгийн газраас баталсан байна. Төсвийн төсөлд төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон зардал, арга хэмжээг тусгахгүй байх заавар чиглэл өгөгдсөн байна.

Монгол улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар Хэнтий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 21,272.6 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 10,112.4 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Хэнтий аймгийн 2023 оны төсвийг батлахдаа улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 21,272.6 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 10,112.4 сая төгрөг, татварын орлогыг 23,337.5 сая төгрөг, татварын бус орлогыг 2,912.4 сая төгрөг, хөрөнгийн орлогыг 250.0 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 402.4 сая төгрөг, бусад тусламжийг 11,951.0 сая төгрөгөөр нийт 70,238.4 сая төгрөгөөр тооцож орон нутгийн төсвийн 165, төсөл сан 61 байгууллагуудыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант онд төсөвт 2 удаа тодотгол хийж орлого, зардлыг 81,754.6 төгрөгөөр баталж анх батлагдсанаас 11,516.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнээс гүйцэтгэлээр 70,976.8 сая төгрөгийг зарцуулж 10,777.8 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

**БҮЛЭГ 1. ХУУЛЬД ЗААСАН ҮНДЭСЛЭЛ БҮРДЭЭГҮЙ БАЙХАД ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙСЭН БАЙНА.****1.1 Төсвийн төсөл боловсруулах удирдамж, чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.**

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг баримталсан боловч журмын 4.2.3<sup>1</sup>-т заалтыг хэрэгжүүлээгүй буюу Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоол “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ыг бүрэн ашиглаагүй байна.

Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 8.3.1<sup>2</sup>-д жилийн төсвийн хязгаарын санал<sup>3</sup>-ыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 8.3.4<sup>4</sup>-т заасны дагуу Сангийн яам 2023 оны төсөв боловсруулах төсвийн удирдамжийг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч 2023 оны төсвийн төсөл боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн 2.2.3, 2.2.4, 2.2.6 дахь чиглэлийг хэрэгжүүлээгүй байна.

Дээрх чиглэлийг баримталснаар орон нутагт хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрөөс эх үүсвэр нэмэгдэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын үйлдвэрлэл борлуулалтын талаар мэдээлэлтэй болсноор татварын орлого нэмэгдэх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ил тод байдал орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын тооцоог хийснээр засаглалыг сайжруулах зэрэг үйл ажиллагааны талаарх тооцоо судалгаатай болох тул дараагийн төсвийн төсөл боловсруулахдаа анхаарч ажиллах, Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж чиглэлийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

**1.2 Төсвийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн байна.**

Орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийн хүрээнд аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 17,165.5 сая төгрөг байхаар тооцон төлөвлөж Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3<sup>5</sup>-д заасны дагуу Сангийн яаманд хүргүүлснийг 2,472.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 19,368.0 сая төгрөгөөр хянасан байна.

**Орлогын төлөвлөлт**

Хүснэгт №1	/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төсвийн төсөлд өгсөн санал	Сангийн яамнаас хянасан	Зөрүү
Нийт орлого	32,323.7	17,165.5	19,638.0	2,472.5
Татварын орлого	28,867.3	15,852.0	17,000.0	1,148.0
Татварын бус орлого	3,456.4	1,208.5	2,638.0	1,429.5
Хөрөнгийн орлого	436.9	105.0		-105.0

<sup>1</sup> Орон нутгийн суурь төсвийн зарлагыг орон нутгийн суурь төсвийн зарлага тооцох аргачлалын дагуу

<sup>2</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх

<sup>3</sup> "жилийн төсвийн хязгаар" гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг

<sup>4</sup> Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх

<sup>5</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх

Өмнөх оны нийт орлогын гүйцэтгэл 32,323.7 сая төгрөг байхад 2023 оны төсвийн саналыг 17,165.5 сая төгрөгөөр боловсруулсан нь орлогыг өмнөх оны гүйцэтгэл, бодит тооцоо судалгаанд үндэслэн нэмэгдүүлэх боломжийг бүрэн дайчилж төлөвлөөгүй байна.

Хэнтий аймгийн 2023 оны суурь зарлагын саналыг 76,251.0 сая төгрөгөөр боловсруулж Сангийн яаманд хүргүүлснийг 46 хувиар бууруулж 40,910.6 сая төгрөгөөр хянасан байна.

#### Төсвийн зарлагын төлөвлөлт

Хүснэгт №2 Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төсвийн төсөл	Сангийн яамнаас хянасан	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>53,952.4</b>	<b>76,251.0</b>	<b>40,910.6</b>	-35,340.40	<b>54%</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	34,236.4	57,027.1	39,132.9	-17,894.20	<b>69%</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,760.9	55,657.1	36,776.9	-18,880.20	<b>66%</b>
ХҮҮ	344.4		1,381.7	1,381.70	
ТАТААС	287.1	402.4	375.9	-26.50	<b>93%</b>
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,844.0	967.7	598.4	-369.30	<b>62%</b>
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,952.7	19,114.2	1,777.6	-17,336.60	<b>9%</b>
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	763.3	109.7	-	-109.70	<b>0%</b>

Хөрөнгийн зардалд 9,191.2 сая төгрөгийн их засвар, 9,923.0 сая төгрөгийн ОНХС-ийн зардал, нийт 19,114.2 сая төгрөг төлөвлөж төсвийн төсөлд хүргүүлсэн боловч Сангийн яам их засварыг 1,777.6 сая төгрөгөөр хянасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1<sup>6</sup>-д заасантай нийцэхгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 16.4 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1<sup>7</sup>-д заасныг зөрчсөн байна.

#### **1.3 Орон нутгийн төсөвт тодотгол хийх үндэслэл бүрдээгүй байхад 3,052.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.**

Тайлант хугацаанд орон нутгийн төсөвт 1 удаа өөрчлөлт, 1 удаа тодотгол хийсэн байна. Үүнд:

- ✓ Аймгийн ИТХ-ын арван наймдугаар хуралдааны 02 дугаар тогтоол “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай”-оор орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 3,052.1 сая төгрөгөөр
- ✓ Аймгийн ИТХ-ын хорьдугаар хуралдааны 07 дугаар тогтоол “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай”-оор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 -т заасныг үндэслэн 2023 оны төсөвт тодотгол хийж төсвийг 8,464.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

#### Төсвийн тодотгол /Орлого/

Хүснэгт №3		/сая төгрөгөөр/				
№	Үзүүлэлт	Аймгийн ИТХ-аар батлагдсан	Тодотгол- 1	Зөрүү	Тодотгол- 2	Зөрүү
1	Орон нутгийн орлого	26,902.3	26,902.3	-	28,955.6	2,053.3
2	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	21,272.6	21,272.6	-	25,201.7	3,929.1

<sup>6</sup> Төсвийн хязгаарыг урсгал болон хөрөнгийн зардлаар тогтоосон байх

<sup>7</sup> Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно

3	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	10,112.4	10,112.4	-	12,451.2	2,338.8
4	Сангуудын эх үүсвэр	5,974.3	5,974.3	-	5,941.2	(32.1)
5	Төрийн сангийн эхний үлдэгдэл	5,976.8	9,028.9	3,052.1	9,204.9	3,228.1
<b>Нийт</b>		<b>70,238.4</b>	<b>73,290.5</b>	<b>3,052.1</b>	<b>81,754.6</b>	<b>11,516.2</b>

Орон нутгийн төсвийг тодотгож батлахдаа анх батлагдсан төсвийг улсын төсвөөс орон нутаг олгох санхүүгийн дэмжлэгийг 3,929.1 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 2,338.8 сая төгрөгөөр, орон нутгийн орлогыг 2,053.3 сая төгрөгөөр, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг 3,228.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, сангуудын эх үүсвэрийг 32.1 сая төгрөгөөр бууруулсан байна.

Нийт зарлагыг анх 70,238.4 сая төгрөгөөр баталж, эхний тодотголоор 3,052.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 73,290.5 сая төгрөг, сүүлийн тодотголоор 8,464.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 81,754.6 сая төгрөгөөр баталсан байна.

### Орон нутгийн зарлагын төлөвлөгөөний харьцуулалт

Хүснэгт №4

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 он						
	Анх баталсан	Тодотгосон төсөв -1	Зөрүү	Тодотгосон төсөв -2	Зөрүү	Зохицуулалт хийгдсэн төсөв	Зөрүү
<b>Б</b>	2	3	4=3-2	5	6=5-3	7	8=5-7
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,238.4	73,290.5	3,052.1	81,754.6	8,464.1	81,754.6	-
УРСГАЛ ЗАРДАЛ	41,999.1	44,255.8	2,256.6	48,213.1	3,957.3	48,225.0	11.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,491.4	42,730.0	2,238.6	46,674.4	3,944.4	46,657.4	(17.0)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,718.0	11,880.6	1,162.6	14,469.6	2,589.0	14,293.2	(176.4)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,343.0	1,489.0	146.0	1,813.3	324.3	1,803.2	(10.1)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,830.7	12,941.1	110.4	12,904.3	-36.8	12,663.5	(240.8)
Хангамж, бараа материалын зардал	1,052.4	1,074.6	22.2	1,110.9	36.3	1,127.6	16.7
Нормативт зардал	635.2	635.2	-	634.1	-1.1	636.3	2.2
Эд хогшил, урсгал засварын зардал	1,096.2	1,157.0	60.9	1,419.5	262.5	1,748.7	329.2
Томилолт, зочны зардал	382.7	441.6	58.9	473.4	31.8	515.4	42.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,822.0	8,104.9	283.0	8,440.9	336.0	8,456.8	15.9
Бараа үйлчилгээний бусад зардал	4,611.2	5,005.9	394.7	5,408.4	402.5	5,412.8	4.4
ТАТААС	700.3	700.3	-	700.3	0.0	700.3	-
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	31.5	31.5	-	31.5	0.0	31.5	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	668.8	668.8	-	668.8	0.0	668.8	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	807.5	825.5	18.0	838.3	12.8	867.4	29.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	151.2	161.1	9.9	161.1	0.0	161.1	-
Бусад урсгал шилжүүлэг	656.2	664.3	8.1	677.2	12.9	706.2	29.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,803.3	23,598.8	795.5	27,229.4	3,630.6	27,217.4	(12.0)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,436.0	5,436.0	-	6,312.1	876.1	6,312.1	-

Эхний тодотголоор нийт зарлагыг 3,052.1 сая төгрөгийн нэмэгдүүлэн баталсан нь Төсвийн тухай хуулийн 34.2<sup>8</sup> дахь заалттай нийцээгүй байна. Үүнд: Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орж орон нутгийн нэмэгдэл олгох болсонтой холбоотой цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1,308.6 сая төгрөгөөр нэмж тодотгосон, бусад зардлыг 1,743.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь үндэслэлгүй байна.

### Төсөвт хийсэн зохицуулалтын талаар:

Тодотгосон төсөвт 2023 онд нийт 439.3 сая төгрөгийн зохицуулалт хийгдсэн байна. Үүнд цалингийн зардлаас 176.4 сая төгрөг, ажил олгогчоос төлөх 10.2 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 240.8 сая төгрөг, хөрөнгийн зардлаас 12.0 сая төгрөгийг эх үүсвэр дутагдсан хангамж, бараа материалын зардалд 16.8 сая төгрөг, томилолтын зардалд 42.0 сая

<sup>8</sup> Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ

төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 139.8 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 29.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Төсвийн зохицуулалт хийхдээ Хэрлэн сумын ЗДТГ-ын хөрөнгийн зардлаас урсгал зардалд 12.0 сая төгрөгийг шилжүүлэн зохицуулалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 42.7<sup>9</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

## БҮЛЭГ2. ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

### 2.1 ААНОАТ-ыг үндэслэлгүй 4,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталснаас аймгийн төсвийн орлого тасарсан байна.

Хэнтий аймгийн орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 81,754.5 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 70,155.1 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

#### Төсвийн санхүүжилтийн эх үүсвэр

Хүснэгт №5

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	11,865.4	25,201.7	25,201.7	-	100.0
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	7,856.3	12,451.2	12,166.2	(285.0)	97.7
Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,740.2	37,766.6	31,211.1	(6,555.5)	82.6
Үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,323.6	1,845.1	1,576.1	(269.0)	85.4
Урьд оны үлдэгдлээс санхүүжих		4,490.0		(4,490.0)	-
Нийт	<b>53,785.5</b>	<b>81,754.6</b>	<b>70,155.1</b>	<b>(11,599.5)</b>	<b>85.8</b>

Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийн 46.8 хувийг орон нутгийн төсвийн орлого, 35.9 хувийг улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, 17.3 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг тус тус эзэлж байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2,217.0 сая төгрөг буюу 107.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №6

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	24,443.4	26,820.2	2,376.8	109.7
Татварын бус орлого	3,868.2	3,657.1	(211.1)	94.5
Хөрөнгийн орлого	250.0	301.3	51.3	120.5
Нийт	<b>28,561.6</b>	<b>30,778.6</b>	<b>2,217.0</b>	<b>107.8</b>

Орон нутгийн төсвийн орлогын 87.1 хувь нь татварын орлогоос, 11.9 хувь нь татварын бус орлогоос, 1 хувь нь хөрөнгийн орлогоос бүрдсэн байна

### Аймгийн татварын орлогын талаар:

Аймгийн төсөвт цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татвар 198.6 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 61.6 сая төгрөг, газрын төлбөрийн 31.7 сая төгрөг, нийт 291.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь

<sup>9</sup> Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.14<sup>10</sup>, 23.8.16<sup>11</sup>, 23.8.17<sup>12</sup> заалтуудтай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрөх орлогыг 8,629.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 5,548.8 сая төгрөг буюу 64.3 хувийн биелэлттэй байна. Энэ нь Сангийн яамнаас хянаж ирүүлсэн ААНОАТ-ыг аймгийн ИТХ-аар 4,000.0 сая төгрөгөөр үндэслэлгүй нэмэгдүүлж баталсантай холбоотой байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №3-аас харна уу)

### Сумдын татварын орлогын талаар:

Сумдын төсвийн орлогыг 19,932.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 25,229.8 сая төгрөгийн орлого төвлөрч 5,297.6 сая төгрөг буюу 26.6 хувиар давж биелсэн байна. Татварын орлогын биелэлтийг авч үзвэл дараах шалтгаантай байна.

- ✓ Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 3,846.9 сая төгрөг буюу 32.2 хувиар давсан нь Төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн доод хэмжээг Засгийн газраас шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.
- ✓ Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 826.9 сая төгрөг буюу 258.6 хувиар давж биелсэн нь Батширээт сумын төвлөрүүлсэн самрын орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.
- ✓ Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 694.0 сая төгрөг буюу 121.2 хувиар давж биелсэн нь тусгай зориулалтын ангийн гүйцэтгэлтэй холбоотой байна.
- ✓ Малын тоо толгойн албан татварын орлого 260.6 сая төгрөг буюу 17.2 хувиар тасарсан нь 2023 онд зуд болж мал хорогдсон холбоотой байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №3-аас харна уу)

Сумдын татварын орлогын биелэлтийг сумдаар авч үзвэл 5 сумын орлогын төлөвлөгөө тасарсан байна. Үүнд:

- ✓ Галшар сумын татварын орлогын гүйцэтгэл 90.7 хувь буюу 33.0 сая төгрөг,
- ✓ Жаргалтхаан сумын татварын орлогын гүйцэтгэл 87.9 хувь буюу 78.9 сая төгрөг,
- ✓ Өмнөдэлгэр сумын татварын орлогын гүйцэтгэл 98.6 хувь буюу 10.0 сая төгрөг
- ✓ Биндэр сумын татварын орлогын гүйцэтгэл 98.8 хувь буюу 7.0 сая төгрөг,
- ✓ Баян-Адарга сумын татварын орлогын гүйцэтгэл 99.6 хувь буюу 1.4 сая төгрөг.

Орлогын төлөвлөгөө их хэмжээгээр тасарсан сумдын татварын орлогын гүйцэтгэл Галшар, Жаргалтхаан сумд

Хүснэгт №7

/сая төгрөгөөр/

Татварын төрөл	Галшар				Жаргалтхаан			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	135.0	129.6	96.0	5.4	175.2	153.8	87.8	21.4
Үйл ажиллагааны орлого	23.0	20.5	89.2	2.5	24.0	6.1	25.5	17.9
Хөрөнгийн орлого	13.0	16.2	124.4	(3.2)	33.0	32.7	99.0	0.3
Хөрөнгө борлуулсны орлого	-	2.3		(2.3)	2.5	1.1	44.8	1.4

<sup>10</sup> Газрын төлбөр

<sup>11</sup> Энэ хуулийн 23.6.11-т зааснаас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

<sup>12</sup> Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	25.0	40.1	160.5	(15.1)	10.0	12.7	126.9	(2.7)
Галт зэвсгийн албан татвар	0.7	0.8	107.1	(0.1)	3.3	3.3	100.0	(0.0)
Малд ногдуулах албан татвар	87.0	41.0	47.2	46.0	89.0	96.9	108.9	(7.9)
Улсын тэмдэгтийн хураамж	2.4	9.8	408.9	(7.4)	2.8	3.8	134.8	(1.0)
ТТАМ	1.7	-	-	1.7	5.0	5.0	100.4	(0.0)
Хог хаягдлын хураамж	10.0	11.7	117.1	(1.7)	20.0	19.0	94.8	1.0
Газрын төлбөр	10.0	9.4	93.7	0.6	25.0	24.4	97.6	0.6
Ойн нөөц ашигласны төлбөр	-	-	-	-	3.5	1.0	27.9	2.5
Агнуурын нөөц ашигласны төлбөр	42.4	38.7	91.3	3.7	170.3	146.6	86.0	23.8
Торгууль	3.5	1.5	44.2	2.0	75.0	61.9	82.6	13.1
Бусад орлого	1.5	0.5	33.3	1.0	11.5	3.0	25.9	8.5
<b>Дүн</b>	<b>355.1</b>	<b>322.1</b>	<b>90.7</b>	<b>33.0</b>	<b>650.1</b>	<b>571.2</b>	<b>87.9</b>	<b>79.0</b>

Дээрх хүснэгтээс орлогын төлөвлөгөө 9.3 хувиас 12.1 хувиар тасарсан Галшар, Жаргалтхаан сумдад цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг хуваарилахдаа тооцоо судалгаанд үндэслээгүй байна. Сумд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг тооцоо судалгаагүй нэмэгдүүлж баталсан нь орлого тасрах нөхцөлийг бий болгожээ.

Орлогын төлөвлөгөөг их хэмжээгээр давуулан биелүүлсэн дараах 3 сум байна.

- Батширээт сумын татварын орлого 310.4 хувь буюу 912.7 сая төгрөгөөр давж биелсэн нь үйл ажиллагааны орлого 15.6 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 20.6 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 720.0 сая төгрөг, бусад орлого 165.2 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна.
- Бор-Өндөр сумын татварын орлого 130.0 хувь буюу 1,481.7 сая төгрөгөөр давж биелсэн нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 1,540.2 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 81.5 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна.
- Хэрлэн сумын татварын орлого 128.1 хувь буюу 1,740.4 сая төгрөгөөр давж биелсэн нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 1,647.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 97.4 сая төгрөг, хөрөнгийн орлого 141.6 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 63.9 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д өөрчлөлт орсноор Хэнтий аймгийн хувьд Хэрлэн, Бор-өндөр сумд аймгийн төсөвт орлого төвлөрүүлдэг болсон. Аймгийн ИТХ-аар сумаас аймагт төвлөрүүлэх орлогыг анх батлагдсан дүнгээс 398.5 сая төгрөгөөр бууруулан тодотгон баталсан байна.

#### Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Хүснэгт №8	/сая төгрөгөөр/			
Сумдын нэр	Анх баталсан 2022.12.05 №06	Тодотгол-1 2023.03.09 №02	Тодотгол-2 2023.07.03 №07	Зөрүү
Бор-Өндөр	608.6	608.6	303.9	(304.7)
Хэрлэн	2,893.0	2,893.0	2,799.2	(93.8)
<b>Нийт</b>	<b>3,501.6</b>	<b>3,501.6</b>	<b>3,103.1</b>	<b>(398.5)</b>

Дээрх сумдын орлогын төлөвлөгөөний биелэлт 128.1-130 хувиар буюу нийт 3,222.1 сая төгрөгөөр давж биелсэн байхад тодотголоор бууруулсан нь үндэслэлгүй, мөн татварын орлогын талаар тооцоо судалгаагүй нь харагдаж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Сангийн яамнаас 2,411.1 мянган төгрөгөөр хянасан байна.

#### Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого

Хүснэгт №9	/сая төгрөгөөр/					
№	Орлогын төрөл	Сангийн яамны хянасан	Анх баталсан	Тодотгол-1	Тодотгол-2	Зөрүү
1	Газар	860.1	973.5	973.5	973.5	113.4
2	Ой	311.0	319.7	319.7	319.7	8.7

3	Ан	320.0	572.5	572.5	572.5	252.5
4	Ус	920.0	923.0	923.0	923.0	3.0
	<b>Дүн</b>	<b>2,411.1</b>	<b>2,788.7</b>	<b>2,788.7</b>	<b>2,788.7</b>	<b>377.6</b>

Сумдын ИТХ-аар Сангийн яамны хянасан орлогыг нийт 377.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын биелэлтийг нэр төрлөөр авч үзвэл газрын төлбөр 110.3 хувь, Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 358.6 хувь, ангийн нөөц ашигласны төлбөрийн орлого 221.3 хувь, усны нөөц ашигласны төлбөрийн орлого 114.7 хувь байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын биелэлтийг агнах барих амьтны тоо хэмжээний хувьд авч үзвэл ахуйн зориулалтын ангийн гүйцэтгэл 56.4 хувь, тусгай зориулалтаар агнах ангийн гүйцэтгэл 86.3 хувь байна. Төлөвлөсөн орлогыг ангийн төрөл хэмжээний хувьд биелүүлээгүй нь төлөвлөгдөөгүй тусгай зориулалтын ан болох шонхрын орлогыг сумын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Иймд зөвхөн шонхрын орлогоос хамраалтай байдлаар ангийн нөөц ашигласны төлбөрийн орлогын биелэлтийг хангаж байгаа нь орлого тасрах эрсдэл үүсгэж байна.

## 2.2 Сангуудын орлого 762.8 сая төгрөгөөр тасарсан байна.

### 2.2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 285.0 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Хэнтий аймгийн хэмжээнд сангуудын орлогыг 17,244.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 16,481.2 сая төгрөг төвлөрүүлж биелэлт 95.6 хувь буюу 762.8 сая төгрөгөөр тасарсан байна.

#### Сангуудын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Хүснэгт №10

/сая төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
А	1	2	3	4=3/2	5=3-2
1	Орон нутгийн хөгжлийн сан	15,771.50	15,272.10	96.8	-499.40
2	Хоршоо хөгжүүлэх сан	1,451.63	1,170.04	80.6	-281.59
3	Байгаль хамгаалах сан	20.9	39.1	187.1	18.20
	<b>Дүн</b>	<b>17,244.03</b>	<b>16,481.24</b>	<b>95.6</b>	<b>-762.79</b>

Дээрх хүснэгтээс харахад Байгаль хамгаалах сангийн төлөвлөгөө 187.1 хувиар давж биелсэн бол Орон нутгийн хөгжлийн сан 3.2 хувь, Хоршоо хөгжүүлэх сан 19.4 хувиар тус тус дутуу биелсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 12,451.2 сая төгрөг, малын тоо толгойн албан татвараас 1,460.3 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 1,860.0 сая төгрөг, бусад орлого 11.5 сая төгрөг, нийт 15,783.5 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 13,272.1 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт Төсвийн тухай хуулийн 60.2.9<sup>13</sup> заалтын дагуу нэмэгдсэн эх үүсвэр байхгүй байна.

<sup>13</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж

Төсвийн тухай хуульд 2022 оны 11 дүгээр сард өөрчлөлт орж 60.11<sup>14</sup> заалтыг хүчингүй болгож 2023 оноос эхлэн ОНХС-ын хөрөнгөөр орон нутгийн суурь зардлыг санхүүжүүлэхгүй байхаар зохицуулалт хийгдсэн байна. Төрийн өмчит байгууллагад олгох татаас /усны татаас/ болох 11.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөнд баталж, аймгийн Засаг дарга данснаас санхүүжүүлсэн алдаа илэрснийг аудитын явцад залруулав.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 96.8 хувь буюу 499.5 сая төгрөгөөр тасарсан нь малын тоо толгойн албан татварын төвлөрүүлэлтээс шалтгаалсан 214.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 285.0 сая төгрөг дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №4-өөс харна уу)

### 2.2.2 Хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг үндэслэлгүй төлөвлөж байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг 1,451.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,170.0 сая төгрөгийг төвлөрүүлж 281.6 сая төгрөг буюу 19.4 хувиар тасарсан байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл  
Хүснэгт №11 /сая төгрөгөөр/

№	Сум	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	1	2	3	4=3-2	5
1	Галшар	20.5	16.6	-3.9	80.8
2	Баянхутаг	30.0	24.4	-5.6	81.5
3	Баянмөнх	15.0	49.4	34.4	329.0
4	Дархан	73.7	27.5	-46.2	37.3
5	Дэлгэрхаан	45.0	8.2	-36.8	18.2
6	Жаргалтхаан	80.2	102.9	22.7	128.3
7	Цэнхэрмандал	10.0	51.5	41.5	514.5
8	Өмнөдэлгэр	56.	59.6	3.7	106.6
9	Батширээт	60.0	28.3	-31.7	47.1
10	Биндэр	0.0	40.0	40.0	
11	Баян-Адарга	50.0	34.2	-15.8	68.4
12	Дадал	55.5	66.9	11.4	120.6
13	Норовлин	59.3	46.1	-13.2	77.7
14	Батноров	50.0	57.9	7.9	115.8
15	Баян-Овоо	50.0	30.8	-19.2	61.5
16	Мөрөн	52.0	32.5	-19.6	62.4
17	Хэрлэн	365.2	265.9	-99.3	72.8
18	Гурван баян	0.0	4.2	4.2	
19	Хэрлэн баян улаан	1.0	1.0	0.0	100.0
20	Өлзийт	0.0	0.2	0.2	
21	Бор-Өндөр	348.3	147.8	-200.4	42.4
22	Бэрх	30.0	74.4	44.4	247.8
	<b>Дүн</b>	<b>1,451.6</b>	<b>1,170.0</b>	<b>-281.6</b>	<b>80.6</b>

Дээрх хүснэгтээс харахад Баянмөнх, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Дадал, Батноров сумд, Хэрлэнбаян улаан, Бэрх тосгод хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн бол Дархан, Дэлгэрхаан, Батширээт, Бор-Өндөр сумдын биелэлт 50-иас доош хувь буюу хангалтгүй байна. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1<sup>15</sup> заалттай нийцэхгүй байна.

Тайлант оны зээлийн авлагын эхний үлдэгдэл 5,416.6 сая төгрөгийн 26.8 хувийг эргэн төлүүлэхээр төлөвлөж биелэлт 80.6 хувь байна. Тайлант оны эхний үлдэгдэлд 5-аас дээш жилийн насжилттай авлага 2,887.0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 4,151.0 сая төгрөг болж чанаргүй хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл нэмэгдсэн байна.

<sup>14</sup> Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй

<sup>15</sup> Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх

Иймд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 тушаал “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 9.3<sup>16</sup>, 10.4<sup>17</sup> заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Сангийн орлогын төлөвлөлтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 тушаал “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 7.1<sup>18</sup>-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байхаар тооцож төлөвлөн төсвийн төсөлд тусгаж, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

### **2.3 Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт 103.1 хувь байна.**

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 393.9 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 406.1 сая төгрөг төвлөрүүлж биелэлт 103.1 хувь байна.

#### Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт №12

					/сая төгрөгөө/	
№	Байгууллагын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	Байгаль хамгаалах сан	20.9	39.1	18.20	187.1	
2	Засаг даргын тамгын газар	65.0	53.2	(11.75)	81.9	
3	Орон нутгийн хөгжлийн сан	-	1.2	1.19		
4	Сум дундын ойн анги	72.9	63.7	(9.18)	87.4	
5	Хот тохижилт	235.2	235.2	-	100.0	
6	Эрсдэлээс хамгаалах сан	-	13.7	13.71		
	<b>Нийт</b>	<b>393.9</b>	<b>406.1</b>	<b>12.17</b>	<b>103.1</b>	

Өөрийн орлогын төлөвлөгөөг 31 байгууллагад нийт 393.9 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч Аймгийн ЗДТГ, Баян-Адарга, Биндэр, Баянмөнх, Батноров, Баянхутаг, Батширээт, Бор-Өндөр, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдын ЗДТГ, Биндэр сумын сум дундын ойн анги, Мөрөн, Цэнхэрмандал сумын Байгаль хамгаалах сан 3.9 хувиас 88.4 хувиар тасалсан байна. Орлогын биелэлтэд 9 байгууллагын 35.3 сая төгрөгийн төлөвлөгөөгүй орлого орсон нь нөлөөлсөн байна.

## **ГУРАВ. ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 86.7 ХУВЬ БАЙНА.**

### **3.1 Хувийн хэвшлийн байгууллагад 324.4 сая төгрөгийн татаас олгосон нь хууль тогтоомжид нийцэхгүй байна.**

Хэнтий аймгийн 2023 оны төсвийн нийт зарлага тодотгосон төсвөөр 81,754.6 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 70,976.8 сая төгрөгийг зарцуулж, 10,777.8 сая төгрөг хэмнэгдсэн байна.

Төсвийн хэмнэлт 10,777.8 сая төгрөгийг хөтөлбөрөөр авч үзвэл 67 хувь буюу 7,207.2 сая төгрөг нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, 19 хувь буюу 2,010.6 сая төгрөг нь орон

<sup>16</sup> Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд тогтмол нийлүүлнэ

<sup>17</sup> Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ

<sup>18</sup> Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр үнэлнэ

нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, 14 хувь буюу 1,560.0 сая төгрөг нь бусад хөтөлбөр, арга хэмжээ байна.

### Төсвийн гүйцэтгэл, хөтөлбөр арга хэмжээний ангиллаар

Хүснэгт №13

/сая төгрөгөөр/

№	Хөтөлбөрийн нэр	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Дүнд эзлэх хувь
1	ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,303.3	3,003.2	300.1	3%
2	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	55,402.5	48,195.3	7,207.2	67%
3	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	270.0	232.5	37.5	0%
4	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	273.7	254.9	18.8	0%
5	ОН-ын төсөвт олгох орлогын шилжүүлэг	3,156.9	1,146.3	2,010.6	19%
6	Мал аж ахуйг хөгжүүлэх	1,860.0	1,760.6	99.4	1%
7	Авто зам	20.0	16.9	3.1	0%
8	Авто тээврийн хяналт, зохицуулалт	470.6	393.3	77.3	1%
9	Ойжуулалт	1,686.9	1,536.5	150.4	1%
10	Байгал орчин хамгаалан нөхөн сэргээх	2,652.1	2,652.1	-	0%
11	Хот байгуулалт, тохижилт	952.4	816.5	135.9	1%
12	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	279.5	277.2	2.2	0%
13	Биеийн тамир спорт	1,926.8	1,795.0	131.9	1%
14	Соёл урлаг	2,092.4	1,935.5	156.9	1%
15	Сургуулийн өмнөх боловсрол	5,883.3	5,472.5	410.8	4%
16	Ерөнхий боловсрол	692.3	682.9	9.3	0%
17	Мэргэжлийн боловсрол	15.5	9.9	5.5	0%
18	Насан туршийн болон албан бус боловсрол	152.7	132.0	20.8	0%
19	Нийгмийн халамж	582.9	582.9	-	0%
20	Хүүхдийн хөгжил, хамгаалал	80.7	80.7	-	0%
<b>Нийт дүн</b>		<b>81,754.6</b>	<b>70,976.8</b>	<b>10,777.8</b>	<b>100%</b>

Төсвийн гүйцэтгэлийг арга хэмжээний ангиллаар авч үзвэл нийт гүйцэтгэлийн 67 хувийг Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, 19 хувийг орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, 4 хувийг Ерөнхий боловсрол, 3 хувийг Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны арга хэмжээ эзэлж байгаа бол бусад 16 арга хэмжээнд 7 хувь зарцуулагдсан байна.

Хэнтий аймгийн ИТХ-ын хорьдугаар хуралдааны 7 дугаар “Хэнтий аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймгийн төсвийн захирагч нарийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын дарга, 3 бүлэг, 14 арга хэмжээ, 114.8 сая төгрөг
2. Аймгийн Засаг дарга, 1 бүлэг, 2 арга хэмжээ
3. Санхүү хяналт аудитын алба, 1 бүлэг, 2 арга хэмжээ
4. Орон нутгийн өмчийн газар, 1 бүлэг, 2 арга хэмжээ
5. Нийгмийн халамж, 1 бүлэг, 1 арга хэмжээ, 152.7 сая төгрөг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаах, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тайлагнахдаа 28 арга хэмжээгээр биелэлтийг 100 хувь, батлагдсан төсвийг 81,754.6 сая төгрөг, 70,851.4 сая төгрөг гэж тайлагнасан байна.

Төлөвлөгөө, тайлан зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5<sup>19</sup>-д заасны дагуу төсвийг батлаагүйтэй холбоотой байна. Иймд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хүрэх үр дүнг үнэлж дүгнэх боломжгүй байна.

## Төсвийн гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар

Хүснэгт №14

/сая төгрөгөөр/

Хөтөлбөрийн нэр	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Гүйцэтгэл хувь	Гүйцэтгэлийн зөрүү
<b>А</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6=4-5</b>	<b>7=5/4</b>	<b>8=5-1</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>53,952.4</b>	<b>81,754.6</b>	<b>70,976.8</b>	<b>10,777.8</b>	<b>87%</b>	<b>17,024.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,236.4</b>	<b>48,225.0</b>	<b>44,094.7</b>	<b>4,130.3</b>	<b>91%</b>	<b>9,858.3</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>31,760.9</b>	<b>46,657.4</b>	<b>43,033.0</b>	<b>3,624.4</b>	<b>92%</b>	<b>11,272.2</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,650.5	14,293.2	12,985.4	1,307.8	91%	3,334.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,212.9	1,803.2	1,605.9	197.2	89%	393.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,679.4	12,663.5	11,723.3	940.2	93%	2,043.9
Хангамж, бараа материалын зардал	823.6	1,127.6	1,099.1	28.5	97%	275.5
Норматив зардал	184.2	636.3	628.5	7.8	99%	444.3
Эд хогшил, урсгал засварын зардал	1,436.3	1,748.7	1,711.8	36.9	98%	275.5
Томилолт, зочны зардал	224.0	515.4	496.3	19.0	96%	272.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,031.7	8,456.8	7,576.2	880.6	90%	2,544.5
Бараа үйлчилгээний бусад зардал	3,518.3	5,412.8	5,206.5	206.3	96%	1,688.2
<b>ХҮҮ</b>	<b>344.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>		<b>(344.4)</b>
<b>ТАТААС</b>	<b>287.1</b>	<b>700.3</b>	<b>352.8</b>	<b>347.4</b>	<b>139%</b>	<b>65.7</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	7.1	31.5	28.4	3.1	90%	21.3
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	280.0	668.8	324.4	344.4	49%	44.4
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,844.0</b>	<b>867.4</b>	<b>708.8</b>	<b>158.5</b>	<b>174%</b>	<b>(1,135.2)</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	829.0	161.1	154.4	6.8	96%	(674.6)
Бусад урсгал шилжүүлэг	1,015.0	706.2	554.4	151.8	79%	(460.6)
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>18,952.7</b>	<b>27,217.4</b>	<b>24,649.4</b>	<b>2,568.0</b>	<b>91%</b>	<b>5,696.7</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>763.3</b>	<b>6,312.1</b>	<b>2,232.7</b>	<b>4,079.4</b>	<b>35%</b>	<b>1,469.5</b>

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 70,976.8 сая төгрөгийн 62.1 хувийг буюу 44,094.7 сая төгрөгийг урсгал зардал, 34.7 хувийг буюу 24,649.4 сая төгрөгийг хөрөнгийн зардал, 3.1 хувийг буюу 2,232.7 сая төгрөгийг эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж байна.

Төсвийн хэмнэлт 10,778.8 сая төгрөгийн 38.3 хувийг урсгал зардлаас, 23.8 хувийг хөрөнгийн зардлаас, 37.8 хувийг эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн хэмнэлт эзэлж байна. Үүнд:

- ✓ Урсгал зардлын хэмнэлтийн 1,307.8 сая төгрөг буюу 31.7 хувийг цалингийн зардал, 940.2 сая төгрөг буюу 22.7 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 880.6 сая төгрөг буюу 21.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал эзэлж байна.
- ✓ Хөрөнгийн зардлын 2,568.0 сая төгрөгийн хэмнэлт нь их засвар 187.6 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалт 367.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 2,012.2 сая төгрөг байна.
- ✓ Эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн 4,079.4 сая төгрөгийн хэмнэлт нь зээлийн эргэн төлөлтөөс орох орлого бүрдээгүйтэй холбоотой байна.

<sup>19</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах

Төсвийн гүйцэтгэл өмнөх онтой харьцуулахад 17,024.5 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд урсгал зардал 9,858.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 5,696.7 сая төгрөг, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 1,469.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

### **Хөрөнгийн зардлын талаар:**

Хөрөнгийн зардалд нийт 27,217.4 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэл 90.6 хувь буюу 24,649.4 сая төгрөг зарцуулж 2,568.0 сая төгрөг хэмнэгдсэн байна.

Нийт хөрөнгийн зардлын 55.8 хувийг ОНХС, 41.3 хувийг Орон нутгийн хөрөнгө оруулалт, 2.8 хувийг сумдын хөрөнгө оруулалт, 0.04 хувийг ЗДТГ-ын хөрөнгийн зардал эзэлж байна.

### Хөрөнгийн зардлын гүйцэтгэл төрлөөр

Хүснэгт №15				/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Их засвар	Тонг	Бусад хөрөнгө			Нийт	
		төхөөрөмж	Ойн анги	ЗДТГ	ОНХО		ОНХС
2022 он	4,011.3	35.9	40.0	1,062.6	4,158.4	9,644.6	18,952.7
2023 он	2,898.0	-	-	10.2	7,981.9	13,759.3	24,649.4
Зөрүү	(1,113.3)	(35.9)	(40.0)	(1,052.4)	3,823.5	4,114.7	5,696.7
Хувь	72.2	-	-	1.0	191.9	142.7	130.0

Хөрөнгийн зардлын гүйцэтгэл өмнөх оноос 5,696.7 сая төгрөгөөр буюу 30 хувиар өссөн байна.

Хөрөнгийн зардлын хэмнэлтийн 7.3 хувь их засвар, 0.02 хувь ЗДТГ-ын хөрөнгийн зардал, 14.3 хувь орон нутгийн хөрөнгө оруулалт, 78.4 хувь орон нутгийн хөгжлийн сан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлд 914.7 сая төгрөгийн 41 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 150 төсөл арга хэмжээ хэрэгжсэнээс 1,097.5 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

### **Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн талаар:**

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийг 6,312.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,232.7 сая төгрөг зарцуулж 4,079.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Тус хэмнэлт нь дамжуулан зээлдүүлэхийн зээлийн эргэн төлөлтөд 2,622.3 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 725.7 сая төгрөг төлсөн, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголтод 3,689.8 мянган төгрөг төлөвлөж 1,507.0 сая төгрөгийн зээл олгосонтой холбоотой байна.

### **Хувийн хэвшлийн байгууллагад олгосон татаасны талаар:**

Тайлант онд хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 668.8 сая төгрөг батлагдаж, 324.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Засаг дарга дансанд 344.4 сая төгрөг батлагдсан боловч гүйцэтгэл гаргаагүйтэй холбоотой байна.

### Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасны төлөвлөгөө, гүйцэтгэл:

Хүснэгт №16		/сая төгрөгөөр/		
Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
Аймгийн Засаг дарга	344.4	-	344.4	
Бэрх ЗАА	324.4	324.4	-	
ДҮН	668.8	324.4	344.4	

Бэрх тосгоны ЗАА-нд 324.4 сая төгрөг батлагдсаныг тосгоны захирагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр Бэрх хөгжил ААТҮГ-д олгосон байна. Энэ нь:

1. Өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах “Бэрх хөгжил” ААТҮГ-т төсвөөс татаас олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйл “Төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилал” 15.2<sup>20</sup> заалттай нийцэхгүй байна.
2. Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-т тодорхойлсноор Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас<sup>21</sup> гэж заасан боловч тухайн байгууллагын тухайн жилийн үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ, алдагдлыг тодорхойлсон тооцоо судалгаагүйгээр олгосон байна.

Иймд дараагийн төсвийн жилд хувийн хэвшлийн байгууллагуудад татаас олгоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

### **3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн 899.4 сая төгрөгийн 37 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.**

Орон нутгийн хөгжлийн сангийн зарлагын төлөвлөгөөг 15,771.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 13,759.3 сая төгрөгийг зарцуулж, биелэлт 87.2 хувь байна. Орон нутгийн хөгжлийн сангийн 49.0 хувь аймагт, 51.0 хувь сумдад зарцуулагдсан байна.

Тайлант онд аймгийн ОНХС-д 37 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,256.3 сая төгрөгийн төсөв баталж 6,738.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн ОНХС-ын 2023 онд хэрэгжүүлсэн 34 арга хэмжээний 54.2 хувь нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёлын үйл ажиллагаанд, 27.8 хувь нь дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, цахилгаан, дулааны шугам сүлжээний ажилд, 16.7 хувь нь орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд, 1.4 хувь нь дулааны станцын ТЭЗҮ, шугам сүлжээний зураг төслийн ажилд тус тус зарцуулагдсан байна.

Тайлант онд 22 сум, тосгодын ОНХС-д 240 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,515.2 сая төгрөгийн төсөв баталж 7,020.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Сум, тосгодын ОНХС-д хөрөнгө оруулалтын 137 төсөл арга хэмжээнд 5,588.5 сая төгрөг, малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр 103 төсөл арга хэмжээнд 1,432.4 сая төгрөг зарцуулсан байна.

#### **Хоршоо хөгжүүлэх сангийн талаар:**

Хоршоо хөгжүүлэх сангаас 3,689.8 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 40.8 хувь буюу 1,507.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Үүнд: Галшар, Баянхутаг, Баянмөнх, Дархан, Дэлгэрхаан, Батширээт, Баян-Овоо сумд болон Хэрлэнбаян-Улаан, Бэрх тосгод зээл олгоогүй нь нөлөөлсөн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 тушаал “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 7.1<sup>22</sup>-д заасан нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлсэн байх шалгуур үзүүлэлтээс шалтгаалж зээл олголт буурсан байна.

#### **Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын талаар:**

<sup>20</sup> Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ

<sup>21</sup> Үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ, эсвэл тухайн жилийн алдагдлыг нөхөх зорилгоор хувийн хэвшлийн байгууллагуудад олгож байгаа татааснууд энд хамаарна

<sup>22</sup> Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр үнэлнэ

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 337.0 сая төгрөгийг зориулалт бусаар буюу хог хаягдлын асуудал шийдвэрлэсэн, хөрөнгө бэлтгэсэн, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.

Иймд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, МУ-ын ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоол "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-д заагдсан арга хэмжээнд төсвийг зарцуулах талаар аймгийн хэмжээнд удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах шаардлагатай байна.

### ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 331.8 сая төгрөгийн 8 алдаа илэрснийг залруулсан байна.

#### ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны нэгтгэл

Хүснэгт №17

/сая төгрөгөөр/

Галшар ЗДТГ	ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн буруу илэрхийлсэн	140.1	Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой
Галшар ИТХ	ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг илүү илэрхийлсэн	3.5	Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой
Галшар ИТХ	ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн буруу илэрхийлсэн	4.3	Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой
Баянхутаг ИТХ	ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг илүү илэрхийлсэн	0.5	Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой
Аймгийн ИТХ	ТШЗ	Батлагдсан төсвийг зориулалт бус зарцуулсан	15.0	Мэдээллийг тусгалгүй орхигдуулсантай холбоотой
Дадал ЗДТГ	ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийг илүү илэрхийлсэн	3.2	Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой
Батноров сумын Засаг дарга	ТТЗ	Төсвийн гүйцэтгэлд тусгаагүй	122.8	Мэдээллийг тусгалгүй орхигдуулсантай холбоотой
ХБУ тосгоны Захирагч	ТТЗ	Төсвийн гүйцэтгэлийн буруу илэрхийлсэн	42.4	Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой
<b>Нийт</b>			<b>331.8</b>	

Нийт алдаа зөрчлийг байгууллагын ангиллаар авч үзвэл 7.0 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, 43.2 хувийг ЗДТГ, 49.8 хувийг сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой байна. Дээрх алдааны 58.5 хувь нь мэдээллийг буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой, 41.5 хувь нь мэдээллийг тусгалгүй орхигдуулсан байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 505.2 сая төгрөгийн 46 зөрчил илэрснээс 77.6 сая төгрөгийн 21 төлбөрийн акт, 330.4 сая төгрөгийн 14 албан шаардлага, 97.2 сая төгрөгийн 11 зөвлөмж хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Нийт зөрчлийн 31.3 хувийг нийцлийн аудитын асуудал, 68.7 хувийг санхүүгийн тайлангийн аудитын асуудал эзэлж байна.

Дээрх алдаа, зөрчлүүд нь төсөв захирагч болон нягтлан бодогчдын ажлын хариуцлага, мэдлэг чадвартай холбоотой байна. Мөн санхүү бүртгэлийн ажилтнуудын хүрэлцээ муутайгаас хяналт тавих албан тушаалыг хавсран гүйцэтгэдэг учраас дотоод хяналтын тогтолцоо алдагдсан нь нөлөөлж байна.

### 3.3 Нэмэлт санхүүжилтийн дансны эцсийн үлдэгдэл 211.4 сая төгрөг нь аймгийн захиалагчийн хяналт дансны үлдэгдэл байна.

Орон нутгийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн харилцах дансны эхний үлдэгдэл 222.5 сая төгрөг байсан бол тайлант онд 4,193.3 сая төгрөгийн орлого төвлөрч, 4,204.5 сая төгрөгийг зарцуулан жилийн эцэст 211.4 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого дараах эх үүсвэрүүдээс бүрдсэн байна. Үүнд:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 28.5 сая төгрөг, 0.7 хувь
- ✓ Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 167.4 сая төгрөг, 4.0 хувь
- ✓ Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,726.3 сая төгрөг, 41.2 хувь
- ✓ Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,271.1 сая төгрөг, 54.1 хувь

Тайлант онд нэмэлт төсвөөс 3,932.3 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 272.2 сая төгрөг төвлөрүүлснээс 237.3 сая төгрөгийг буцааж олгохоор санхүүгийн тайланд авлагаар тусгаж, 34.9 сая төгрөгийг орон нутгийн орлого болгосон байна. Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 211.4 сая төгрөг нь захиалагчийн хяналт дансны үлдэгдэл байна.

### 3.4 Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан хуульд заагдсан бүрэлдэхүүн хэсгийг бүрэн хангасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн 54.4<sup>23</sup>, 54.5<sup>24</sup>-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг бүрэн хангасан тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэх үүрэгтэй. Үүний дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2024 оны 04 сарын 03-ны өдрийн 9/667 тоот албан бичгээр ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8.9.4<sup>25</sup> хуулийн хугацаатай нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын газарт ирүүлэх санхүүгийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хэнтий аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг авч үзвэл:

Тайлан, мэдээлэл	Тайлбар
Тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/	2024.04.03-ны өдрийн 9/667 тоот албан бичгээр ирүүлсэн.
Татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт	2024.04.03-ны өдрийн 9/667 тоот албан бичгээр ирүүлсэн.
Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл	2024.04.03-ны өдрийн 9/667 тоот албан бичгээр ирүүлсэн.
Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	2024.04.03-ны өдрийн 9/667 тоот албан бичгээр ирүүлсэн.
Нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга	2024.04.03-ны өдрийн 9/667 тоот албан бичгээр ирүүлсэн.

<sup>23</sup> Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна

<sup>24</sup> Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна

<sup>25</sup> Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

Аймгийн Засаг даргын Төрийн аудитын газарт ирүүлсэн аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан нь хуульд заасан бүрэлдэхүүн хэсгийг бүрэн хангасан байна.

#### **БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Төрийн аудитын тухай хуульд заасан үндсэн зорилтын хүрээнд төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад аудитын үйл ажиллагаа чиглэгдэж ирсэн. Засгийн газраас 2021 онд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэн ажиллах “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг батлан мөрдүүлсэн. Мөн 2022 оны 5 дугаар сард “Төрийн хэмнэлтийн тухай хууль” шинээр батлагдан мөрдөгдөж, энэ хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар Засгийн газрын 203, 204 дүгээр тогтоол батлагдсан.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол улсын Ерөнхий аудиторовын А/59 тоот тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэл”-ийг, А/89 тоот тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг тус тус баталсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зорилт нь төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

Дээрх зорилгын хүрээнд ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хамааралтай шалгуур үзүүлэлтийн дагуу горим сорил гүйцэтгэхэд 131.8 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 3.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 108.7 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 20.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

1. Норовлин сумын Засаг даргын тамгын газар төсвийн 1.0 сая төгрөгийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн.
2. Хэрлэн сумын ИТХ хууль тогтоомжид заагдаагүй 1.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
3. Аймгийн ИТХ төсвийн 1.0 сая төгрөгийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн.
4. Хэнтий Ус ХХК-д 108.7 сая төгрөгийн тендер шалгаруулалт зохион байгуулаагүй.
5. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөр 20.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж дэмжлэг олгосон.

Дээрх зөрчлүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.5 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана”, 15.1.3 “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.5 “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” заалтыг зөрчсөн байна.

Өмнөх ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 350.5 сая төгрөгийн 38 зөрчил илэрч байсан бол тайлант онд 62.4 хувиар буурсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт өөрчлөлтүүдтэй холбоотой байна.

МУ-ын Засгийн газрын 2022 оны 203 дүгээр тогтоол “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын хүрээнд дараах арга хэмжээг авч ажилласан байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн төслийн саналаа боловсруулах болсон.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн иргэдийн санал авсан, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн.

Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан гаргасан МУ-ын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолд суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа автомашиныг тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасан байна.

Авто машины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан гарсан МУ-ын Засгийн газрын 2023 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилт 23.7 хувь байна. Энэ нь төрийн байгууллагуудын авч хэрэгжүүлэх шат шатны арга хэмжээ хийгдээгүйтэй холбоотой байна.

Мөн орон нутгийн өмчийн бүртгэл, авто тээврийн газрын бүртгэлийн системийн мэдээлэл 224 тээврийн хэрэгслээр зөрүүтэй байгаа нь Орон нутгийн өмчийн газрын бүртгэлд шилжилт хөдөлгөөн, хасалт хийгдээгүй зэргээс шалтгаалсан байна.

Иймд Орон нутгийн өмчийн газар өөрийн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж тээврийн хэрэгслийг акталж данснаас хасах, байгууллага хооронд шилжүүлэх шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, хянах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

## **БҮЛЭГ 5. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.**

### **5.1 Орон нутгийн хөрөнгө оруулалт нь аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг түүний зорилтыг хангахад чиглэсэн байна.**

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэн 50 төсөл, арга хэмжээг Хэнтий аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй нийцүүлэн, зорилтыг хангахад чиглүүлэн төлөвлөсөн байна.

#### Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

Хүснэгт №18

/сая төгрөгөөр/

д/д	Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Төсөл, арга хэмжээний тоо
1	АЗДҮАХ 2.1.10	Зорилт 2.2	1
2	АЗДҮАХ 2.1.9	Зорилт 2.2	6
3	АЗДҮАХ 2.4.11	Зорилт 2.4	1
4	АЗДҮАХ 2.4.3	Зорилт 5.2	9
5	АЗДҮАХ 2.5.6	Зорилт 1.4	4
6	АЗДҮАХ 3.3.6	Зорилт 8.3	1
7	АЗДҮАХ 3.5.9	Зорилт 4.2	2
8	АЗДҮАХ 5.1.4	Зорилт 2.4, 7.2	1
9	АЗДҮАХ 5.1.5	Зорилт 2.4, 7.2	1
10	АЗДҮАХ 5.1.6	Зорилт 2.4, 7.3	6
11	АЗДҮАХ 6.1.6	Зорилт 2.1, 8.1	18
12	АЗДҮАХ 6.1.7	Зорилт 8.1	4
	Нийт		54

*Харин Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг үзэхэд Бэрх тосгоны орон сууцын байруудын дээврийн их засварын ажил нь Төрийн*

хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2<sup>26</sup> -т заасныг баримтлаагүй боловч тус арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдахаас өмнө хэрэгжиж эхэлсэн байна.

## 5.2 Дийлэнх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуульд заасан шалгуурыг ханган төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын төсөл арга хэмжээг баталжээ.

Тус төсөл, арга хэмжээнд 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоол, 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 2 удаа тодотгол хийн 24,706.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 56 төсөл, арга хэмжээг 12,540.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Үүнээс хөрөнгө оруулалтад 7,595.0 төгрөг, их засварт 3,085.8 төгрөгийг, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд 1,860.0 төгрөгийг баталсан байна.

### Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл

Хүснэгт №19

/сая төгрөгөөр/

ИТХ-ын тогтоол	Хөрөнгө оруулалтын дүн	Их засварын дүн	Нийт
2022.12.05-ны №06	5,876.3	2,945.3	10,511.6
2023.03.09-ны №02	6,446.0	2,945.3	11,101.3
2023.07.03-ны №07	7,595.0	3,085.7	12,540.7

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр хэрэгжүүлэхээр тусгагдсан барилга, байгууламж, их засварын 15 төсөл, арга хэмжээний зураг төсөл, хяналтын төсөв нь магадлалаар баталгаажсан бол бага үнийн дүн бүхий 2 ажлын зураг төсвийг магадлалд оруулаагүй байна. Үүнд:

1. Багийн төвийн барилга /Биндэр сумын Баян-Өндөр баг, Галшар сумын Оч баг/ 90.0 сая төгрөг
2. Нэгдсэн эмнэлгийн яаралтай хүлээн авах хэсгийн засвар 16.0 сая төгрөг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг [www.publicinvestment.gov.mn](http://www.publicinvestment.gov.mn) цахим системд 2022 оноос оруулж эхэлсэн боловч орон нутгийн 2023 оны хөрөнгө оруулалтыг мэдээллийг оруулах талаар чиглэл ирээгүй тул цахим системд мэдээлэл оруулаагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө 2023 онд шинээр эхлүүлсэн 17 ТАХ-ээс 3 төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 29.3.5<sup>27</sup> дахь заалтад нийцэхгүй боловч тус заалтыг 2023 оны 7 сард оруулсан нэмэлт өөрчлөлт бөгөөд тус ажлууд нь хуулийн өөрчлөлтөөс өмнө төлөвлөгдсөн байна. Үүнд:

1. Сургуулийн барилгын их засвар /Цэнхэрмандал сум/
2. Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдын 4-н айлын орон сууцны барилгын их засвар /Дархан сум/
3. Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны их. засвар /Батноров сум, Бэрх. тосгон/

<sup>26</sup> Хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ

<sup>27</sup> Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг дэд бүтцийн бүтээн байгуулалт, барилга байгууламж барих болон засварлах, гадна тохижилт дарааллаар эрэмбэлж төсвийн хөрөнгө оруулалтад тусгасан бол 2023 онд эхлүүлсэн төсөл, арга хэмжээний дийлэнх нь урсгал зардал, ажлын байр шаардагдахгүй төсвийн байгууллагуудын засвар үйлчилгээ, автозамын ажлууд, стадионы бүтээн байгуулалт зэрэг эдийн засгийн үр ашиг тооцохгүй боловч нийгмийн ач холбогдол ихтэй ажлууд тусгагдсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтад эрчим хүчний хэмнэлттэй хөрөнгө оруулалт, ногоон хөрөнгө оруулалтын шинж чанарыг агуулсан төсөл, арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд энэ чиглэлийн хөрөнгө оруулалт нь өртөг өндөртэй, орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтад хэрхэн нэвтрүүлэх талаар мэдээлэл хомс тул хэрэгжилт хангалтгүй байна.

### **5.3 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн ажлууд бүрэн хэрэгжиж дууссан байна.**

Тайлант оны жилийн эцсийн байдлаар хөрөнгө оруулалтад 7,350.2 сая төгрөгийг, их засварт 2,844.1 сая төгрөгийг, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ажилд 1,760.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нийт хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд тусгахдаа хөрөнгө оруулалтаар хийгдсэн 54.0 сая төгрөгийг их засварын зардалд тусган бүртгэсэн алдааг аудитын явцад залруулав.

#### Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Хүснэгт №20

					/сая төгрөгөөр/	
д/д	Хөрөнгө оруулалтын төрөл	Санхүүгийн тайланд тусгасан дүн	Нэмэгдүүлэх дүн	Хасах дүн	Аудит хийгдсэн дүн	
1	Хөрөнгө оруулалт	7,296.2	54.0		7,350.2	
2	Их засвар	2,898.0		54.0	2,844.1	
	<b>ДҮН</b>	<b>10,194.3</b>			<b>10,194.2</b>	

Хөрөнгө оруулалт, их засвар болон орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээг 12,424.7 сая төгрөгөөр бүртгэхээр шийдвэр гарснаас 11,884.0 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж, 540.7 сая төгрөгийн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

#### Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Хүснэгт №21

					/сая төгрөгөөр/	
д/д	Гэрээний дүн	Нийт бүртгэсэн хөрөнгийн дүн	Үүнээс:		Олгоогүй санхүүжилт	
			Бүртгэсэн	Бүртгээгүй		
1	Хөрөнгө оруулалт	5,090.4	5,070.6	20.0	79.5	
2	Их засвар	4,798.4	4,277.6	520.7	89.4	
3	Орон нутгийн замын сан	2,535.8	2,535.8	0.0	55.1	
	<b>ДҮН</b>	<b>12,424.7</b>	<b>11,884.0</b>	<b>540.7</b>	<b>224.0</b>	

**БҮЛЭГ 6. ӨМНӨХ АУДИТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ****6.1 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 98.9% байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 7,882.3 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс 1,929.6 сая төгрөгийн 3 зөрчилд 3 албан шаардлага, 5,952.7 сая төгрөгийн 5 зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн байна. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хүснэгтээр харуулбал.

**Зөвлөмжийн хэрэгжилт**

Хүснэгт №22

/сая төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /Сая төгрөг/	Шийдэл	Биелэлт	Байгууллагаас ирүүлсэн тайлбар, тодруулга
1	Баянмөнх сумын төсөв 7.9 сая төгрөгөөр, Батноров сумын төсөв 40.0 сая төгрөгөөр зөрүүтэй. Үндсэн үйл ажиллагааны орлого 14.6 сая төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлого 11.2 сая төгрөг, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 588.8 сая төгрөг, ОНХС-ийн шилжүүлэг 167.8 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байна.	830.5	Зөвлөмж	100%	Төсвийн төлөвлөлтийн фискал программд сумдын төсөв баталсан тогтоолыг үндэслэн төсвийг зориулалт , хөтөлбөрийн дагуу үнэн зөв шивж оруулсан.
2	Жаргалтхаан сумын Байгаль хамгаалах сангийн 15.6 сая төгрөгийн төлөвлөгөө, 8.5 сая төгрөгийн гүйцэтгэлийн хөтөлбөрийг 70106 код бүхий орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт бүртгэсэн байна.	24.1	Зөвлөмж	100%	Төсвийн төлөвлөлтийн фискал программд сумдын төсөв баталсан тогтоолыг үндэслэн төсвийг зориулалт , хөтөлбөрийн дагуу үнэн зөв шивж оруулсан. Мөн бүх сумдын байгаль хамгаалах сангийн зардлыг "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх" зориулалт дээр шивсэн.
3	ААНОАТ-ын 2,002.6 сая төгрөгийг урьдчилж авсан байна.	2,002.6	Зөвлөмж	100%	АИТХ-р 2023 оны Аж ахуй нэгжийн орлогын албан татварыг 4650.0 сая төгрөгөөр баталсан. 2023 онд тус албан татварыг урьдчилж аваагүй бөгөөд гүйцэтгэл 2594.5 сая төгрөгийн биелэлттэй буюу 55.8 хувийн биелэлттэй гарсан.
4	Хоршоог хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө 3,077.6 сая төгрөгөөр тасарсан байна	3,077.6	Зөвлөмж	100%	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийг эргэн төлөлтийг нэмэгдүүлэх зорилгоор Шилэн Хэнтий арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж аймгийн хэмжээнд хугацаа хэтэрсэн зээлдэгчийн мэдээллийг Сошиалд ил тод болгон ажилласан. Ингэснээр зээл эрчимтэй төлөгдөж байна. 2023 онд нийт авлага 5,4 тэрбум үүнээс 1 тэрбум 43 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна.
5	Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих төлөвлөгөөг 18.0 сая төгрөгөөр илүү тусгасан байна.	18.0	Зөвлөмж	100%	Төсвийн төлөвлөлтийн фискал программд сумдын төсөв баталсан тогтоолыг үндэслэн төсвийг зориулалт , хөтөлбөрийн дагуу үнэн зөв шивж оруулсан
6	Аймгийн батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллагаар тулгахад Засаг дарга дансанд 293.2 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалтад 562.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.	855.4	Албан шаардлага	100%	2023 онд батлагдсан төсвийн хуваарийн дагуу сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 12626.1 сая төгрөг, Аймгийн төвийн улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардалд 1565.9 сая төгрөг, Аймгийн төвийн орон нутгийн төсөвт байгууллагууд, сангууд 25905.3 сая төгрөг буюу нийт 40097.3 сая төгрөгийг тус тус олгосон. Мөн 2024 оны батлагдсан төсвийг хуваарийн дагуу олгон албан шаардлагын биелэлтийг ханган ажиллаж байна.
7	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлтээс 330.0 сая төгрөгийг урсгал засварын зардалд шилжүүлэн зохицуулалт хийн зарцуулсан байна.	330.0	Албан шаардлага	100%	Байр ашиглалтын зардлыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэл болон Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны үнэ тариф тогтоосон тогтоолууд мөн байгууллагын эзлэхүүнийг хяналтын хэмжилт хийсэн бодит хэмжээгээр тооцож, хэрэгжилтийг ханган ажилласан.

8	Хэмнэгдсэн зардлын 744.2 сая төгрөг нь үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.	744.2	Албан шаардлага	90%	Төсвийн төсөлд улсын төсвийн байгууллагуудын урсгал засварын зардлыг 1013.9 сая төгрөгөөр тусган саналаа хүргүүлсэн боловч Сангийн яамнаас 425.4 сая төгрөгөөр батлан ирүүлсэн нь "Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал"-ыг баримтлан урсгал засварын зардлыг тооцон төсөвт тусгахад бэрхшээлтэй байна.
<b>Зөрчлийн дүн</b>		<b>7,882.3</b>		<b>98.9</b>	

### Аудитын илрүүлэлт:

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар 65.5 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээний 54.0 сая төгрөгийн гүйцэтгэлийг их засварын зардалд бүртгэсэн
2. Орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төлөвлөгөөг 11.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 7,810.9 сая төгрөгийн 9 зөрчил илэрснээс 693.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 7,052.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр **70,155.1** сая төгрөгийн нийт орлого ба тусламж, **70,976.8** сая төгрөгийн нийт зарлага ба зээлийн дүнг аудитаар баталгаажуулав.

1. Аймгийн төсвийн нийт орлого **30,778.6** сая төгрөгөөр буюу **107.8** хувиар давж биелсэн байна.
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг үндэслэлгүй төлөвлөж нэмэгдүүлснээс аймгийн татварын орлого тасарсан байна.
3. Төсвийн тухай хуулиар сумын төсөвт төвлөрүүлэх **291.9** сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.
4. Төсвийн төлөвлөлтийг холбогдох тооцоо судалгаанд үндэслэлгүй, төсвийн удирдамжийг бүрэн баримтлаагүй боловсруулсан байна.
5. Сумаас аймагт төвлөрүүлэх орлогыг бодит судалгаанд үндэслэн тооцож төлөвлөөгүй байна.
6. Орон нутгийн төсөвт тодотгол хийх үндэслэл бүрдээгүй байхад 3,052.1 сая төгрөгийн төсвийн тодотгол хийсэн байна
7. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.
8. Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл **86.7** хувьтай байна.
9. Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт 324.4 сая төгрөгийн татаас олгосон нь хууль тогтоомжид нийцэхгүй байна.
10. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээ үр дүнтэй байна.
11. Өмнөх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.
12. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ЗГ-ын 2022 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.
13. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв батлахдаа Төсвийн тухай хуулийн 22.6.5-д заалтыг бүрэн мөрдөөгүй байна.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

1. Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн удирдамж чиглэлийг бүрэн баримталж төсвийн төслийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж байх
2. Аймаг, сумын татварын орлогын төсвийн төслийг боловсруулахдаа өмнөх онуудын гүйцэтгэл болон татварын нөөц боломжийг бүрэн дайчлан төлөвлөж биелэлтийг хангах, сумын төсөвт орох татварын орлогыг аймагт төвлөрүүлэхгүй байх
3. Аймгаас сумын төсөвт хуваарилах орлого, сумдаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг тухайн сумын татварын орлогын нөөц боломжид үндэслэн төлөвлөж, хуваарилах
4. Төсвийн тодотголыг Төсвийн тухай хуульд заасан шаардлага, үндэслэлийн дагуу хийж байх
5. Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, эдийн засаг, хөтөлбөр, арга хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнгийн хамт баталж байх

Хавсралт №1

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>81,754.6</b>	<b>70,976.8</b>	<b>-10,777.8</b>	<b>86.8%</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>48,225.0</b>	<b>44,094.7</b>	<b>-4,130.3</b>	<b>91.4%</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>46,657.4</b>	<b>43,033.0</b>	<b>-3,624.4</b>	<b>92.2%</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,293.2	12,985.4	-1,307.8	90.8%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,803.2	1,605.9	-197.2	89.1%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,663.5	11,723.3	-940.2	92.6%
2104	Хангамж, бараа материалын зардал	1,127.6	1,099.1	-28.5	97.5%
2105	Нормативт зардал	636.3	628.5	-7.8	98.8%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,748.7	1,711.8	-36.9	97.9%
2107	Томилолт, зочны зардал	515.4	496.3	-19.0	96.3%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,456.8	7,699.0	-757.8	91.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,412.8	5,083.7	-329.1	93.9%
211	<b>ХҮҮ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	
212	<b>ТАТААС</b>	<b>700.3</b>	<b>352.8</b>	<b>-347.4</b>	<b>50.4%</b>
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	31.5	28.4	-3.1	90.3%
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	668.8	324.4	-344.4	48.5%
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>867.4</b>	<b>708.8</b>	<b>-158.5</b>	<b>81.7%</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	161.1	154.4	-6.8	95.8%
2132	Бусад урсгал шилжүүлэг	706.2	554.4	-151.8	78.5%
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,217.4</b>	<b>24,649.4</b>	<b>-2,568.0</b>	<b>90.6%</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>6,312.1</b>	<b>2,232.7</b>	<b>-4,079.4</b>	<b>35.4%</b>
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>81,754.6</b>	<b>70,155.1</b>	<b>-11,599.4</b>	<b>85.8%</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	75,419.5	68,579.0	-6,840.5	90.9%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	
34	ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,335.1	1,576.1	-4,759.0	24.9%
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.0	0.0	0.0	
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>5,449.6</b>	<b>5,449.6</b>	
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>4,627.9</b>	<b>4,627.9</b>	

Хавсралт №2

## АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,204.5</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,817.7</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,524.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14.3
2104	Хангамж, бараа материалын зардал	75.9
2105	Нормативт зардал	12.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	274.4
2107	Томилолт, зочны зардал	28.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	496.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,582.7
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>293.6</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	21.4
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	272.2
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>386.8</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	386.8

I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,193.3</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,193.3</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	28.5
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагадаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	167.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,726.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,271.1
III	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>11.1</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	222.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	211.4

Хавсралт №3

**АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ**

/сая төгрөгөөр/

д/д	Орлогын төрөл	Орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
A	1	2	3	4	5
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого		198.6		(198.6)
2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,000.0)	(752.1)	75.2	(247.9)
3	ҮХХ-ийн албан татвар		61.6		(61.6)
4	АТБӨЯХ-ийн албан татвар	470.0	692.8	147.4	(222.8)
5	ААН-ийн татвар	4,650.0	591.9	12.7	4,058.1
6	Газрын төлбөр		31.7		(31.7)
7	Газрын дуудлага худалдаа	700.0	752.8	107.5	(52.8)
8	ҮҮЗАУс-ны төлбөр	920.0	1,045.1	113.6	(125.1)
9	Улсын тэмдэгтийн хураамж	163.1	204.8	125.6	(41.8)
10	Хүү торгуулийн орлого	2,111.9	887.7	42.0	1,224.2
11	Бусад орлого	364.4	1,532.6	420.6	(1,168.2)
12	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө худалдсаны орлого	250.0	301.3	120.5	(51.3)
<b>Аймгийн орлогын дүн</b>		<b>8,629.4</b>	<b>5,548.8</b>	<b>64.3</b>	<b>3,080.6</b>
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	11,960.8	15,609.1	130.5	(3,648.3)
2	Үйл ажиллагааны орлого	461.0	456.9	99.1	4.1
3	Хөрөнгийн орлого/хад.хүү.ор/	1,036.0	1,207.1	116.5	(171.1)
4	ҮХХБОрлого /2 хувь/	277.4	286.7	103.4	(9.3)
5	БОНАТ		0.5		(0.5)
6	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	620.5	686.3	110.6	(65.8)
7	Галт зэвсгийн албан татвар	47.2	47.1	99.9	0.0
8	Малд ногдуулах албан татвар	1,460.3	1,199.7	82.2	260.6
9	Улсын тэмдэгтийн хураамж	80.1	153.9	192.3	(73.9)
10	ТТАМ	75.1	64.1	85.4	11.0
11	Хог хаягдлын хураамж	653.4	781.7	119.6	(128.3)
12	Газрын төлбөр	973.5	1,073.4	110.3	(99.9)
13	Ойн нөөц ашигласны төлбөр	319.7	1,146.6	358.6	(826.9)
14	Агнуурын нөөц ашигласны төлбөр	572.4	1,266.4	221.2	(694.0)
15	Ус рашаан ашигласны төлбөр	3.0	13.5	450.0	(10.5)
16	Торгууль	849.7	787.9	92.7	61.8
17	Бусад орлого	542.2	448.9	82.8	93.3
<b>Сумын орлогын дүн</b>		<b>19,932.2</b>	<b>25,229.8</b>	<b>126.6</b>	<b>(5,297.6)</b>
<b>Нийт орлогын дүн</b>		<b>28,561.6</b>	<b>30,778.6</b>	<b>107.8</b>	<b>(2,217.0)</b>

Хавсралт №4

**СУМДЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ**

Хүснэгт №10

(сая төгрөгөөр)

д/д	Сумдын нэр	Орлого				
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү	Дүнд эзлэх хувь
A	1	2	3	4	5	6
1	Галшар	355.1	322.1	90.7	33.0	1.3
2	Баянхутаг	306.5	350.2	114.3	(43.7)	1.4
3	Баянмөнх	333.4	434.8	130.4	(101.4)	1.7
4	Дархан	547.6	585.9	107.0	(38.3)	2.3
5	Дэлгэрхаан	528.8	730.4	138.1	(201.6)	2.9
6	Хэрлэн баян улаан	65.6	77.3	117.8	(11.7)	0.3
7	Жаргалтхаан	650.1	571.2	87.9	78.9	2.3

8	Цэнхэрмандал	709.3	720.8	101.6	(11.5)	2.9
9	Өмнөдэлгэр	720.5	710.5	98.6	10.0	2.8
10	Гурванбаян	148.9	175.8	118.1	(26.9)	0.7
11	Батширээт	433.7	1,346.4	310.4	(912.7)	5.3
12	Биндэр	563.4	556.4	98.8	7.0	2.2
13	Баян-Адарга	352.0	350.6	99.6	1.4	1.4
14	Дадал	722.5	847.3	117.3	(124.8)	3.4
15	Норовлин	380.8	474.5	124.6	(93.7)	1.9
16	Батноров	733.8	859.9	117.2	(126.1)	3.4
17	Бэрх	358.5	521.6	145.5	(163.1)	2.1
18	Баян-Овоо	382.9	549.3	143.5	(166.4)	2.2
19	Бор-Өндөр	4,935.2	6,416.9	130.0	(1,481.7)	25.4
20	Мөрөн	373.6	550.5	147.4	(176.9)	2.2
21	Хэрлэн	6,200.3	7,940.7	128.1	(1,740.4)	31.5
22	Өлзийт	129.7	136.7	105.4	(7.0)	0.5
<b>Дүн</b>		<b>19,932.2</b>	<b>25,229.8</b>	<b>126.6</b>	<b>(5,297.6)</b>	<b>100.0</b>

Хавсралт №5

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ**

/сая төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
А	1	2	3	4=3/2	5=3-2
1	Аймгийн ОНХС	7,256.3	6971.3	96.1	285.1
2	Батноров	498.7	423.4	84.9	75.3
3	Бэрх	146.2	147.4	100.9	(1.3)
4	Батширээт	378.9	427.3	112.8	(48.4)
5	Баян-Адарга	368.6	352.5	95.6	16.1
6	Баянмөнх	302.4	298.2	98.6	4.2
7	Баян-Овоо	391.1	407.7	104.2	(16.6)
8	Баянхутаг	289.8	282.8	97.6	7.0
9	Биндэр	546.8	549.0	100.4	(2.2)
10	Бор-Өндөр	763.8	759.3	99.4	4.5
11	Галшар	320.7	274.7	85.7	46.0
12	Дадал	497.7	492.7	99.0	5.0
13	Дархан	433.5	429.8	99.1	3.7
14	Дэлгэрхаан	265.1	235.3	88.8	29.8
15	Хэрлэнбаян улаан	25.3	26.1	103.3	(0.8)
16	Жаргалтхаан	264.1	264.1	100.0	-
17	Мөрөн	266.2	252.7	94.9	13.4
18	Норовлин	411.9	449.5	109.1	(37.6)
19	Өмнөдэлгэр	679.0	616.9	90.8	62.1
20	Хурх	94.7	92.4	97.6	2.3
21	Хэрлэн	1,031.4	1032.8	100.1	(1.5)
22	Өлзийт	82.1	82.1	100.0	(0.0)
23	Цэнхэрмандал	457.4	404.2	88.4	53.2
<b>Дүн</b>		<b>15,771.5</b>	<b>15,272.02</b>	<b>96.8</b>	<b>499.5</b>

Хавсралт №5

**Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын биелэлт**

Хүснэгт №11

/сая төгрөгөөр/

Сумд	Төлөвлөгөө					Гүйцэтгэл					Биелэлт
	Газар	Ой	Ан	Ус	Нийт	Газар	Ой	Ан	Ус	Нийт	
Галшар	10.0		42.4		52.4	9.4		38.7		48.0	91.8
Баянхутаг	7.0		38.7		45.7	8.0		147.2		155.2	339.9
Баянмөнх	2.0		38.7		40.7	1.5		143.3		144.8	355.3
Дархан	150.0		0.6		150.6	178.5		0.9	0.8	180.2	119.7
Дэлгэрхаан	40.0	2.4	70.1	3.0	115.5	83.1	4.6	174.1	12.6	274.5	237.6
Жаргалтхаан	25.0	3.5	170.3		198.8	24.4	1.0	146.6		171.9	86.5
Цэнхэрмандал	100.0	22.8	0.4		123.1	122.0	27.2	0.4	0.0	149.6	121.5
